

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ
/2024 оны жилийн эцэс/

2025 оны 01 дүгээр сарын 02

Улаанбаатар хот

Ус сувгийн удирдах газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь 2024 онд 8 өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн. Үүнд:

- Ёс зүйтэй холбоогүй тул холбогдох зохион байгуулалтын нэгжид шилжүүлсэн – 3 өргөдөл, гомдол
- Ёс зүйн зөрчилд тооцож, дүгнэлт гаргасан – 1 өргөдөл, гомдол
- Ёс зүйн хэм хэмжээг мөрдөж ажиллах тухай зөвлөмж хүргүүлсэн – 4 өргөдөл, гомдол

Ёс зүйн зөрчилд тооцох тухай дүгнэлтийг үндэслэн 1 албан хаагчид байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 13 дугаар зүйлийн 13.2.3 дахь заалтын дагуу үндсэн цалинг 1 сарын хугацаагаар 20 хувь бууруулах сахилгын шийтгэлийг ногдуулсан байна.

Ажилтны ёс зүйн дүрэм шинэчлэгдэж, ёс зүйн дэд хороо шинэчлэгдэн байгуулагдсантай холбогдуулан ажилтны ёс зүйн дүрэм, ёс зүйн дэд хорооны талаарх товч танилцуулгыг 20 зохион байгуулалтын нэгжийн 1023 ажилтанд танилцуулсан.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ажилтны ёс зүйн зарчим, хэм хэмжээний талаарх мэдээллийг 6 төрлийн 10 постероор гарган байгууллагын фэйсбүүкт байршуулан нийт ажилтнуудад түгээсэн.

УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО